Улсын хоёрдугаар эмнэлгийн
2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
........... дугаартай албан бичгийн Хавсралт 1

# ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
2023 оны эхний хагас жилээр

Байгууллагын нэр: Улсын хоёрдугаар төв эмнэлэг

БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

| № | Мэдээлэл | Танилцуулга /тайлбар/ |
|---|---|---|
| 1 | Байгууллагын хаяг, утас, цахим хаяг, факс, цахим хуудас | Баянзүрх дүүрэг, энхтайваны өргөн чөлөө-49, утас-70150308, факс-70150200,<br>Цахим хаяг: info@ssch.gov.mn<br>Цахим хуудас: http://www.ssch.gov.mn |
| 2 | Байгуулагдсан огноо | 1931 он |
| 3 | Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичигдсэн үйл ажиллагааны чиглэл | Төв эмнэлгийн тусламж үйлчилгээ |
| 4 | Магадлан итгэмжлэгдсэн удаа огноо | 2011 оны 12 дугаар сарын 16<br>2013 оны 12 дугаар сарын 16<br>2017 оны 12 дугаар сарын 16<br>2021 оны 12 дугаар сарын 16<br>2022 оны 12 дугаар сарын 16 |
| 5 | Барилга байгууламжийн талаарх мэдээлэл (нийт талбай) | Эмнэлгийн эзэмшлийн 37.943.0498 кв.м |
| 6 | Нийт орны тоо | 365 |
| 7 | Эмнэлгийн бүтэц | Ерөнхий захиралд шууд харьяалагдах 3 алба, 3 дэд захирал, бусад 9 алба, 4 төв, 23 тасаг, 3 хэсэгтэй нийт 42 алба, төв, тасаг, хэсэгтэй. |

| | | |
|---|---|---|
| 8 | Хүний нөөцийн хангалт | Батлагдсан орон тоо-566<br>Одоо ажиллаж байгаа-527 (2023 оны 07 сарын 01-ний өдрийн байдлаар) |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

1. ЗГ-Засгийн газар
2. УОК-Улсын онцгой комисс
3. ЭМЯ-Эрүүл мэндийн яам
4. ЭМС-Эрүүл мэндийн сайд
5. ЭМХТ-Эрүүл мэндийн хөгжлийн төв
6. УХТЭ-Улсын хоёрдугаар төв эмнэлэг
7. ЦТЭ-Цэргийн төв эмнэлэг
8. ҮОЭТ-Үндэсний оношилгоо, эмчилгээний төв
9. БОЭТ-Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
10. ЭМТҮЧАБА-Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба
11. ОНӨТҮГ- Орон Нутгийн Өмчит Төсөвт Үйлдвэрийн Газар
12. KOFIH- Korea Foundation for International Healthcare
13. БНХАУ-Бүгд Найрамдах Хятад Ард Улс
14. БНСУ-Бүгд Найрамдах Солонгос Улс

| № | A | B | C | D | E | F | G | H |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа /өөрийн байгууллага болон орон нутагт хамааруулж тайлан гаргана/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилт */Strengths/* /зарцуулсан санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэр, шийдвэр байгаа бол заавал бичнэ/ | Сул тал */Weaknesses/* | Сайжруулах боломж */Opportunities/* | Хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй зүйл */Threats/* |
| **Нэг. Эрүүл мэндийн ажилтны аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийг нь хамгаалах** | | | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг тогтмол хугацаанд холбогдох талуудтай хамтран үнэлэх, шаардлагатай дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх | Үнэлгээний тайлан; Шинэчилсэн дүрэм, журмын тоо | Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангагдсан байна. | Батлагдсан журмын дагуу зааварчилгаа батлагдсан байна | Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоолын 4.1.4 заалт, Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/32 дугаар тушаалыг үндэслэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөвлөйн ажиллах дүрэм | - | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгийн ерөнхий захирлын тушаалаар баталж, мөрдөн ажиллаж байна. | | | |
| 2. | Эрүүл мэндийн байгууллага бүрт ослыг тэглэх, осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх | Ослын тоо<br>Мэргэжлийн шалтгаалсан өвчлөлийн тоо | Үйл ажиллагааны төлөвлөгөө. Хэрэгжилтийн тайлан./Хавсралтаар ирүүлэх/ | 1 | 0 | 2023 оны эхний хагас жилийн байдлаар Үйлдвэрлэлийн осол, гэмтэл, хурц хордлого бүртгэгдээгүй. | - | - | - |
| 3. | Эрүүл мэндийн байгууллага, нэн тэргүүнд төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар үе шаттай хийлгэх | | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ. Сайжруулах ажиллагааны тайлан /Тайланг хавсралтаар ирүүлнэ үү/ | Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийгдэнэ. | Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл сайжирсан тасаг нэгжийн тоо | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл 3 тасгийн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх шийдвэр гарсан. Ажлын үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагаас судалгааа авч байна. | - | Эмнэлгийн ажилтнуудын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар үе шаттай хийлгэх | - |
| 4. | Эрүүл мэндийн ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг холбогдох талуудтай хамтран тогтмол хугацаанд үнэлж, шинэчлэх | | Үнэлгээ, шинэчлэл | Шинэчлэн баталсан Хөдөлмөрийн дотоод журмын дагуу эмнэлгийн удирдах ажилтан, хэсэг, тасаг, албадын батлагдсан 566 орон тооноос 43 албан тушаалтантай "Хөдөлмөрийн | Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу батлагдсан орон тооноос 523 ажилтнуудтай | Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу батлагдсан орон тооноос 523 ажилтнуудтай нэг бүрчлэн хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан. | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гэрээ" шинээр болон шинэчлэн байгуулсан. | хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан байна. | | | | |
| 5. | “Тэтгэврийг хөнгөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д салбарын ажил, мэргэжлийн жагсаалт, шинээр нэвтэрч байгаа техник, технологитой уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах | Шинэчлэгдсэн жагсаалт | Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1 дүгээр заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 147,628,418 төгрөгийг 187 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон | Хууль тогтоомжид заасны дагуу нөхцлийн нэмэгдэл олгох | Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1 дүгээр заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 118 553 277 төгрөгийг 122 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. | Энэ холбогдох байгууллагаас санал аваагүй. | - | - |
| 6. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлийн сургалт, сурталчилгааг эрүүл мэндийн ажилтнуудад тогтмол зохион байгуулах | Зохион байгуулагдсан сургалтын тоо | Хамтарсан сургалт зохион байгуулагдсан байна. | Сургалтын ирц, тоо | - ХАБЭА-н зөвлөл нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, *аюулгүй хөдөлмөрийн эрүүл ахуйн* чиглэлийн сургалт, жилийн сургалтын хөтөлбөр батлуулсан эмнэлгийн удирдах ажилтан сургалтыг “Хүний хөгжил хөлдөлмөр хамгаалал” Төрийн бус мэргэжлийн байгууллгаас сургалт хийгдэж 38 ажилтан танхимаар, онлайнаар 10 эмч нар нийт 48 ажилтан оролцов.<br>- Нийт 21 тасаг алба нэгжүүдэд ХАБ-ын ажилтан “Аюулгүй ажиллах ажлын байр”, “Гал аюулгүй байдал, галын хорыг ажиллуулж сурах” сэдэвтэй | Арутгагач нарт зориулсан давтан сургалтын хөтөлбөр байхгүй, эмч сувилагч нартай харьцуулахад мэргэжил дээшлүүлэх болон мэдлэг дээшлүүлэх албан ёсны сургалт байхгүй. | Нийслэлийн хэмжээнд анх удаагаа “Ариутгагчийн нэг өдөр” сэдэв өдөрлөг, сургалт зохион байгуулсан нь ариутгагчийн мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тэмдэглэлт | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтыг нийт ажилчдын 350 хүний 75% оролцсон байна.<br>- 2023 оны хөдөлмөр хамгаалал сарын аяны хүрээнд мэргэжлийн байгууллагаас “Гал импекс” ХХК-ны сургагч багш А.Батмөнх “ Галын аюулгүй байдал, газар хөдлөлд бэлэн байх, газар хөдлөлт, түүнийг авах арга хэмжээ” сэдэвтэйгээр зохион байгуулж нийт ажилчдад 50%-тай оролцов. Мөн эмч нарт “Хөдөлмөр хамгаалал удирдлагын тогтолцоо ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвтэй сургалтыг “Хүний хөгжил хөдөлмөр хамгаалал “ТББ-н захирал Ц.Дуламсүрэн хийгдэж нийт 32 эмч 35% оролцов.<br>- Халдвар хяналтын чиглэлээр 2023 оны байдлаар дотооддоо олон эмэнд тэсвэртэй бичил биетний, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр эрсдэл бүхий тасаг, нэгжүүдийн сувилагч, туслах сувилагч, үйлчилгээний ажилчдад тусгайлан 5 удаагийн сургалт хийсэн бөгөөд нийт 250 сувилагч тусгай мэргэжилтнүүд хамрагдсан мөн 2022 оны 6 дугаар сараас 2023 оны 3 дугаар сарыг хүртэл шинээр ажилд орсон эмч, сувилагч, бусад мэргэжлийн 70 эрүүл мэндийн | Эрүүл мэндийн ажилтнууд зориулсан танхмийн сургалтаас илүүл цөөн хүн оролцсон ажлын байран дээрх сургалтын тоог нэмэгдүүлэх, үр дүнг тооцох | өдөртэй болгох, мэргэжил нэгтнүүдтэйгээ мэдлэгээ хуваалцах, тэдний санал хүсэлтийг хүлээн авах зэрэг давуу талтай Дэмжих сангаас төсөл авч хэрэгжүүлсэн нь давуу талтайх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилчдад 2 удаагийн сургалт зохион байгуулаад байна.<br>- 2023 оны эхний улиралд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын сайжруулах сэдэвт ЭМЯ дэмжих сангийн төслийг хэрэгжүүлж Үйлчлүүлэгчийн аюулгүй орчин, Хяналт үнэлгээ-чанартай үйлчилгээ сэдэвт 2 сарын аян зохион байгуулж Хяналт- үнэлгээ чанартай үйлчилгээ сэдвээр нийт тасаг нэгжийн халдвар хяналтын багийнхан тасаг тус бүрдээ сургалт зохион байгуулж цахим хаягт байршуулсан 25 тасаг нэгжийн 250 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан Танхимын 6 удаагийн сургалт зохион байгуулж 70 эрүүл мэнлийн ажилтан хамрагдсан.<br>- Аяны төгсгөлд 2023 оны 3 дугаар сарын 24 өдөр өдөрлөг зохион байгуулсан.Өдөрлөгт нийт 36 алба, тасаг нэгжүүд оролцож 22 мэдээлэл өгөх ширээ ажиллуулсан.Өдөрлөг зохион байгуулах ажлын хүрээнд өдөрлөгийн үйл ажиллагааны 26 заалт 2023/03/20 бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулж эмнэлгийн захирлаар батлуулсан. Өдөрлөгийн төлөвлөгөөг тасгийн эрхлэгч төвийн дарга нарт цахим болон цаасаар танилцуулсан. Ширээ тус бүрийг хариуцсан тасгийн эрхлэгч, ахлах сувилагч, эрүүл мэндийн | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилтантай уулзаж мэдээлэл өгсөн. Өдөрлөгийн үеэр халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр 22 ширээ ажиллах ба ширээ бүрт 2 тасаг үйл ажиллагаа явуулна. Өдөрлөгийн үйл ажиллагаанд үйлчлүүлэгч болон 2022-2023 онд шинээр ажилд орсон 149 эрүүл мэндийн ажилтанг оролцуулсан. ТВ25, Arslan.mn сайтаар мэдээлэл дамжуулсан. Өдөрлөгийн үеэр нийт 22 ширээ ажилласан. Ширээ бүр халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр өөр өөрийн онцлогтой байлаа.<br>- 2023 оны байдлаар халдвараас сэргийлэх хяналтын чиглэлээр шинээр ажилд орсон үйлчлэгч, сувилагч, сувилагчийн туслах нийт 66 эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан.<br>- Ариутгал халдваргүйтгэлийн тасгаас “Ариутгагчийн нэг өдөр” сургалт хэлэлцүүлэгч МТХСЭН хамтран аймаг нийслэлийн 34 эрүүл мэндийн байгуулагийн 63 ариутгагчид оролцож ариутгалын түүхэн хөгжил, түүхэн замнал, ариутгагчийн ажлын байран дээрх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа талаар сургалт зохион байгуулсан. Сургалтын төгсгөлд ариутгагч нарын дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж 6-7 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ариутгагчид ажлын байран дээр тулгарч буй асуудлын талаар ярилцсан<br>- Дэлхийн гар угаах өдрийг тохилдуулан Гарын эрүүл ахуй сахилтыг нэмэгдүүлэх 14 хоногийн аян зохион байгуулж, 2 удаагийн сургалт, үнэлгээ ажиглалтын судалгааг 2022 оны 6 дугаар сараас 2023 онд ажилд шинээр орсон 70 эрүүл мэндийн ажилчид багаар хуваагдан ажиглалтын судалгаа болон гар угаах нөхцлийг үнэлж тайлан тавьсан. Сургалтын үр дүнд сайжруулжруулах шаардлагатай зүйлсийн талаар хэлэлцсэн. Мөн аяны хүрээнд видео бичлэгийн уралдаан зарлаж 11 бичлэгээс Яаралтай тусламжийн тасаг шилдэг бичлэгээр шалгарч талархал мөнгөн шагналаар шагнасан. 100 эрүүл мэндийн ажилтны гарын эрүүл зүйн шинжилгээ авсан. | | | |
| 7. | Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны талаарх мэдлэгийг сайжруулах сургалтыг тогтмол зохион байгуулах | Зохион байгуулагдсан сургалтын тоо | 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр “Хөдөлмөрийн эрүүл ахуйн тухай” сургалтыг эмнэлгийн нийт 42 удирдах ажилтан, дунд шатны менежер нарт Хөдөлмөрийн хамгаалал, хүний хөгжлийн төв ТББ-ын тэргүүн | Удирдах ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны талаарх мэдлэгийг сайжруулах сургалт | 2023 оны 04 дүгээр сарын 11-нд ХАБЭА-н зөвлөл нь эмнэлгийн удирдах ажилтаны сургалтыг “Хүний хөгжил хөлдөлмөр хамгаалал” Төрийн бус мэргэжлийн байгууллгаас сургалт зохион байгуулж 38 ажилтан танхимаар, онлайнаар 10 эмч нар нийт 48 ажилтан оролцов. | | Сургалтын давтамж болон сургалтын үргэлжлэх хугацааг нэмэгдүүлэх | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | С.Дуламсүрэн, хуулийн зөвлөх Болорчимэг нар зохион байгуулсан. | зохион байгуулах | | | | |
| 8. | Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан нэгдсэн загвар бүхий ажлын хувцас, ажлын хэрэгслээр бүрэн хангаж, тогтмол хугацаанд шинэчлэх | Зарцуулсан хөрөнгө | 2022 онд Их уул трейд ХХК-тай №НХЗЭ/22/02 тоот нормын хувцас худалдах худалдан авах гэрээг 50,736,000 төгрфгөөр, "Оюу гандирс ХХК"-тай №НХЗЭ/22/03 тоот цагаан хэрэглэл, даавуу, хулдаас, худалдах худалдан авах гэрээг 114,890,000 хийгдсэн. 2. 2022 оны нормын хувцас тоо 20ш 50,736,000 төгрөгний гэрээг хийсэн. 3. Нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгсэл тасаг нэгжүүдэд хүрэлцээтэй 2022 онд N95 маск 4504ш 6510720 төгрөг, малгай 26996ш 5399200 төгрөг, комбинзон 11920ш 37360000 төгрөг, улавч 17700ш 4238000, бээлий 724900 ш 448132000 төгрөгийн нөөцийг татан авсан. | 2023 онд 18 нэр төрлийн эрүүл мэндийн ажилтан бүрт 3 ээлжийн нормын хувцас худалдан авах. | Захиргааны ажилчдын хүрэм /оффис загвар/ бүхий 40 ш, тасгийн эрхлэгчийн богино халаад 50 ш, эмч халад-200ш, эмчийн өмд цамц- 200 хос, сувилагч өмд цамц 230 хос, угаагч, нярав, нар өмд цамц 14 хос, туслах сувилагч (ариутгагч) өмд цамц 13 хос, үйлчлүүлэгчийн өмд цамц 64 хос, инженерийн хувцас өмд цамц 14 хос, техникч, слесарийн хувцас өмд цамц 13 хос, жолооч өмд цамц 10 ш, цахим бүргэлийн ажилтан, хөтөчийн хувцас 13 хос, хоол зөөгчийн хувцас (өмд цамц) 5 хос, тогоочийн хувцас 8 хос, ажлын өвлийн хувцас (хүрэм, өмд) 30 хос, гадуур хүрэм 70 ш, гадуур цамц (сувилагч) 25 ш, өвчтөний хувцас 530 хос нормын хувцасыг энэ жилд худалдан авах тендерт тусган худалдан авахаар төлөвлөсөн. 2 удаагийн нээлттэй тендер зарласан ба нийлүүлэлт хийх газар байхгүй тул шууд гэрээ хийхээр төлөвлөсөн байна.<br>- Мөн ажил мэргэжлийн онцлогт тохируулан ажлын шаахай 40 хос, хошуувч буюу хоол үйлдвэрлэлийн үед эрүүл ахуйн байдлын хамгаалах зорилгоор хийгдсэн маск 500 ш, халуунд тэсвэртэй 30 ш хормогч, ус чийг цохилт даралтыг тэсэх ган хамгаалттай | Тасгийн эрхлэгч болон албадын дарга нарт зориулж богино халадаад хангалт хийсэн.Мөн үйлчлүүлэгч нарт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед өмсөх хувцасаар хангаж ач тухтай байдлыг бүрдүүлсэн. | Нийт ажилтнууд дотоодын үйлдвэрлэгчийн нормын хуцваснаас илүүл дэлхийн брендийн эрүүл мэндийн ажилтны хувцас өмсөх сонирхол ихтэй байгаа боловч тендерийн хуулийн дагуу худалдан авалт хийх боломж хязгаарлагдмал байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлын гутал (зуны) 10 хос, Өвлийн дулаан, цохилт даралты тэсэх ган хамгаалалттай ажлын гутал (өвлийн) 10 хос гутал тус бүр энэ жилийн худалдан авах тендер тусгасан. Цацрагаас хамгаалах нүдний шил, тугалжуулсан талгай, хормогч, бамбайн хамгаалалт, хантааз зэрэг туяанаас хамгаалах хэрэгслийг тус бүр 5ш худалдан авахаар төлөвлөсөн. | | | |
| 9. | Шөнийн ээлжинд гарсан эмч, эмнэлгийн мэргэжилтнийг заавал биеэр амруулах эрх зүйн зохицуулалт бий болгож, хэрэгжүүлэх | Батлагдсан шийдвэр Биеэр амралтыг эдлүүлсэн баримт -ажлын цагийн бүртгэл, илүү цагийн мөнгө | - Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 138,924 цагийн 138,924,000 төгрөг олгогдсон<br>- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1,581,542,311 төгрөгийг давхардсан тоогоор нийт 2,970 | Шөнийн ээлжид гарсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанг заавал биеэр амруулахахад хяналт тавих, зайлшгүй тохиолдолд илүү цагийн хөлс олгох | - Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 40384 цагийн 80 768 000 төгрөг олгогдсон.<br>- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 1 296 685 547 төгрөгийг давхардсан тоогоор нийт 1886 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. | - | Шөнийн ээлжинд гарсан эмнэлгийн мэргэжилтэн болон ажилчдыг заавал биеэр эдлэх зохицуулалтын явцыг эмнэлгийн захиргаа, удирдлагын зүгээс хяналттай ажилладаг | Сувилагч мэргэжилтний хомсдол |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. | | | | | |
| 10. | Эрүүл мэндийн байгууллага бүр албан үүргээ гүйцэтгэж байх үедээ заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн эрүүл мэндийн ажилтныг хууль эрх зүйн туслалцаа авахад дэмжлэг үзүүлэх | Гэрээгээр хуульч ажиллуулдаг эсэх ? Дэмжлэг авах шаардлагатай ажилтны тоо / Дэмжлэг авсан ажилтны тоо | Гэрээгээр хуулийн зөвлөх ажиллуулдаг. | Гэрээгээр хуулийн зөвлөх ажиллуулах | Эрүүл мэндийн байгууллага бүр албан үүргээ гүйцэтгэж байх үедээ заналхийлэл, хүчирхийлэлд өртсөн эрүүл мэндийн ажилтныг хууль эрх зүйн туслалцаа авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хуулийн зөвлөхийг гэрээгээр ажиллуулж хууль, эрх зүйн зөвөлгөө, тусламж авч байна. | 7 хоногт 1 удаа эмнэлэг дээр биеэр ирж ажиллаж байна. | - | - |
| 11. | Эрүүл мэндийн ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хяналтанд авах, эмчлэн эрүүлжүүлэх журмыг батлан, эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлэх | Батлагдсан журам Урьдчилан сэргийлэх үзлэгийн тайлан | Эмнэлгийн эрүүл мэндийн ажилтны 2022 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах тухай” ерөнхий захирлын 2022 оны 03 сарын 04-ны А/28 тоот тушаал гаргасны дагуу үзлэг зохион байгуулагдсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулан ажиллаа. Үзлэгт хамрагдвал зохих 524 ажилтанаас 498 | Тушаалын дагуу 2023 оны 11 дүгээр сард үзлэгийн үр дүнг танилцуулах | - 2023 оны 6 сарын 8-ны өдрийн Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирлын А/61 тоот тушаалын дагуу эмнэлгийн эрүүл мэндийн ажилтны 2023 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 6 сарын 12-ноос зохион байгуулж эхэлж байна. Энэ жилийн урьдчилан сэргийлэх үзлэг нь 2 үе шаттай бөгөөд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг амралтын өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн нь үзлэгийн чанар, ажилтны хамрагдалт, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилготой.<br>- 2023 онд шинээр ажилд орсон нийт 53 ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулсан. | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүн лабораторийн болон багажийн шинжилгээ, 439 хүн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамрагдсан байна. Мөн энэ онд давхардсан тоогоор 162 ажилтан эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Эдгээрээс 65 ажилтанд яаралтай болон төлөвлөгөөт байдлаар мэс заслын асуудал шийдвэрлэжээ | | | | | |
| 12. | Эрүүл мэндийн ажилтанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг шинэчлэн баталж мөрдүүлэх | Багталгдсан журам, тайлан | Холбогдох дээд байгууллагаас журам батлагдаагүй байна | Эрүүл мэндийн яамнаас батлагдсан журам | Эмнэлгийн Ерөнхий захирлын 2022 оны А/51 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн баталсан. Уг журамд эмнэлгийн эрүүл мэндийн ажилтан, тэдний гэр бүл, 18 нас хүртэлх хүүхдийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамруулах заалт тусгасан. | Холбогдох дээд байгууллагаас журам батлагдаагүй байна | - | - |
| 13. | Элэгний С вирусийн халдвар илэрсэн эрүүл мэндийн ажилтнуудыг вирусийн эсрэг эмчилгээнд үргэлжлүүлэн үнэ, төлбөргүй хамруулах | Элэгний С вирусийн эмчилгээнд үнэ төлбөргүй хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо Урьдчилан сэргийлэ | Нийт 545/36 (6.6%) нь В,С вирус тээгч байна. 24 (4.6%) нь В вирус тээгч, 16 (3%) нь С вирус тээгч байна. ВД вирусын хавсарсан халдвартай 1 эрүүл мэндийн ажилтан байна. | Элэгний С вирусийн халдвар илэрсэн эрүүл мэндийн ажилтнуудыг вирусийн эсрэг эмчилгээнд үргэлжлүүлэн үнэ төлбөргүй хамруулах | 2023 оны байдлаар элэгний С вирусийн халдвар илэрч эмчлүүлсэн 18 эрүүл мэндийн ажилтан бүртгэгдсэн байна.<br>Үүнээс энэ оны байдлаар элэгний С вирусын халдвар шинээр оношлогдсон эрүүл мэндийн ажилтан бүртгэгдээгүй. | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | х үзлэгийн тайлан | | | | | | |
| 14. | Эрүүл мэндийн байгууллага ажилтнуудаа ажлын байранд сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авах боломжоор хангах | Гэрээгээр сэгэл зүйч ажиллуулдаг эсэх Үзүүлсэн тусламж үйлчилгээний тоо, тайлан | - "Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ'' багц цагийн сургалтанд эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулса<br>- Содура консалтинг ХХК зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хамтран нийт эмнэлгийн ажилтнуудад 4 удаа ёс зүй, харилцаа, хандлага, манлайлал гэсэн сэдвүүдээр сургалт явуулсан.<br>- ”Стресс менежмент ба харилцаа” сэдвээр АУ-ны доктор, сэтгэл заслын эмч, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэд захирал Н.Алтанзул 04-р сарын 12-нд нийт 120 гаруй эмч, сувилагч, ажилтанг хамруулсан сургалт зохион байгуулсан. | Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ авсан байдал | - Сувилахуйн алба ЭМЕЗСХороо хамтран дараах ёс зүйн сургалтыг явуулсан. Амьдралд суурилж суралцахуй ТББ-д УХТЭ -ийн Сувилахуйн албаны (Ёс зүйн салбар хороо)-ны зүгээс “Мэргэжилтэний ёс зүй-Харилцааны ур чадвар 1 багц цагийн сургалтыг УХТЭ-ийн эмч, сувилагч, эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн, ажилтануудад авах хүсэлт илгээсний дагуу тасралтгүй хөгжүүлэх нэн чухал асуудал болж буй эмнэлгийн мэргэжилтний Ёс зүй-Харилцаа хандлагын сургалтыг 2023 оны 02 дүгээр сарын 14-ний 14.00 цагт ҮОЭТ-ийн хурлын танхимд АШУҮИС-ийн БАС-ийн тэнхимийн багш С.Наранчимэг /АУ-ны доктор, профессор/, С.Нармандах /докторант/ нартай хамтран зохион байгуулж нийт 124 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан.Сургалтын үр дүнд эмч, сувилагч, эмнэлгийн ажилтууд биеэ авч яваа байдал, өөрийн бодол, биеийн хэлэмж, үгийн сонгол, дууны өнгөөс сэтгэлээсээ хандаж буй эсэхэд анхаарах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид хэрхэн яаж хүрэх зэргээр дадлага онол хосолсон сургалт боллоо. эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд болон | Гэрээгээр сэтгэл зүйч ажиллуулдаггүй | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - УХТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо "Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээ" сэдвээр 2 удаа багц цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 360 эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг хамруулсан. | | үйлчлүүлэгч, БЗД-ийн хамрах хорооны иргэдэд "Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж" сэдэвт 2 багц цагийн сургалтын удирдамжийг Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хяналтын хорооны дарга, ЭМХТ-өөр батлуулан 2023 оны 09 сард хийхээр төлөвлөн ажиллаж байна. | | | |
| 15. | Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндийн байгууллага хөдөлгөөн өрнүүлэх | Тоо | - Дэлхийн эмч нарын баярын өдрийг тохиолдуулан спортын 3 төрөлт нөхөрсөг тэмцээнийг 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр өдөр зохион байгуулсан.<br>- Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн байгууллагагынхан Эрүүл мэндийнхээ төлөө - "Алхангаа ярилцая" явган алхалтын арга хэмжээнд эмнэлгийн 3 тасгийн 25 ажилтан Үндэсний цэцэрлэгт | Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндийн байгууллага хөдөлгөөн өрнүүлэх | - ЭМЯ-наас 2023 оны туршид хүн амын дунд зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор зохистой хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих замаар таргалалтыг бууруулах "Энэ жилдээ-эрүүл жиндээ" аяныг үндэсний хэмжээнд өрнүүлж байгаа билээ. Энэхүү аяны хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Цэргийн төв эмнэлгийн (ЦТЭ)-ийн мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад сурч байгаа резидент, суралцагч нарын дунд нөхөрсөг спортын 4 төрөлт тэмцээнийг 05 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, | Хамт олны таатай уур амьсгалыг нэмэгдүүлсэн. Ажилтнууд хоорондоо танилцах давуу талтай. | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүрээлэнд ярилцангаа алхсан. | | тэргүүн байранд шалгарсан баг тамирчдад батламж, медаль, мөнгөн шагналыг гардуулав. Тус тэмцээний үеэр УХТЭ, ЦТЭ-ийн резидент, суралцагч эмч нар нь дотносон танилцахын зэрэгцээ хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх, тоглолтын техник ур чадвараа дээшлүүлсэн, тоглолтын арга туршлага солилцсон нөхөрсөг тэмцээн болж өндөрлөө.<br>- МУ-ын ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар "ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" үндэсний фестиваль Улаанбаатар хотноо 2023 оны 5 сарын 31-нд амжилттай зохион байгуулагдлаа. Тус үйл ажиллагаанд эмнэлгийн хамт олон хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэгийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, зөв эрүүл хооллолтын талаар ХБЭС-ийн нарийн мэргэжлийн зөвлөх, тэргүүлэх, ахлах зэргийн болон залуу эмч нар оролцож 300 гаруй иргэдэд үзлэг хийн, зөвлөгөө өгч, 15 зөвлөмжийг цахим болон тараах материал ашиглан хийсэн нь иргэдийн сэтгэлд хүрсэн үйл ажиллагаа байлаа.<br>- Олон Улсын Сувилагчдын өдрийг угтан 5 сарын 8-12 ны өдрүүдэд гайхамшигтай сонгодог хөгжмийн эгшигээр Улсын Филармонийн хөгжимчид Ө.Болормаа, Д.Энхмаа нартаа | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон МУГБ Д.Наранцацрал багштай "Дэм - Авьяастан" Хүүхдийн хөгжмийн сургалтын төвийн авьяаслаг хүүхдүүд төгөлдөр хуур тоглов.<br>- Жил бүрийн тавдугаар сарын 12-ны өдөр дэлхий нийтээр "Олон улсын сувилагчдын өдөр"-ийг тэмдэглэдэг уламжлалтай. энэ жил эмнэлгийн Сувилахуйн албанаас "Бидний сувилагч, Бидний ирээдүй" уриан дор өнөөдөр "ЦУСАА БЭЛЭГЛЭЕ" сайн үйлсийн аяныг уриалан нэгдсэн арга хэмжээг зохион байгууллаа. Энэ үеэр эмнэлгээс хамгийн олон удаа цусаа бэлэглэсэн доноруудыг алдаршууллаа. Үүнд:<br>- • 20 удаа цусаа өгсөн донороор Э.Энхболд<br>- • 10 удаа цусаа бэлэглэсэн донороор Ө.Энхбаяр, А.Алехан нарыг онцлон алдаршуулав.<br>- Эмнэлгийн санаачлагаар зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын спортын 5 төрөлт тэмцээн Багануур дүүрэгт 2 өдөр амжилттай болж өндөрлөлөө. Энэ удаагийн нөхөрсөг уулзалт тэмцээн нь "ЭНЭ ЖИЛДЭЭ ЭРҮҮЛ ЖИНДЭЭ" үндэсний хэмжээний аяныг сурталчлах, эрүүл мэндийн ажилтнууд үлгэрлэн манлайлах зорилгоор нийт 7 байгууллагын 200 гаруй тамирчид авъяас самбаагаа уралдуулан өндөр зохион | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулалтын дор өрсөлдлөө. Багийн дүнгээр Багануур эрүүл мэндийн төв шилжин явах цом 1-р байр, УХТЭ 2-р байр, Сүхбаатар нэгдсэн эмнэлэг 3-р байрыг тус тус эзлэв. 2024 онд зүүн бүсийн спортын наадам Сүхбаатар аймагт зохион байгуулагдахаар тохирлоо.<br>- Үйлдвэрчний эвлэлийн нэрэмжит байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээн 06 дугаар сарын 09-өөс 17-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөллөө.<br>- 2023 оны 06 сарын 21-нд Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсролын төв, Нийгмийн эрүүл мэнд, тандалтын алба хамтран эмнэлгийн дэмжих албаны 68 ажилчдад ажлын байран дахь эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал зуршил, хамт олны дотоод харилцаа, уур амьсгал сэдэвт эрүүл мэндийн сургалтыг зохион байгууллаа. | | | |
| **Хоёр. Эрүүл мэндийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг сайжруулах** | | | | | | | | |
| 1. | Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг үе шаттайгаар эхлүүлэх | төгсөлтийн дараах сургалтын төлөвлөгөө, тайлан | 2021-2022 оны хичээлийн жилд Дотрын анагаах судлал, Дүрс оношилгоо судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал, Эрчимт эмчмлгээ судлал нийт 5 чиглэлийн үндсэн мэргэшлийн сургалтад 120 резидент эмч суралцаж, 34 эмч | Төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах | 2022-2023 оны хичээлийн жилд шинээр дотрын анагаах судлалд 13, дүрс оношилгоо судлалд 13, мэс засал судлалд 10, мэдрэл судлалд 1, яаралтай тусламж судлалд 1 резидент эмч тус тус элсэн суралцснаар 1-р дамжаанд 38 резидент эмч суралцаж байна.<br>2-р дамжаанд дотрын анагаар судлалд 38, дүрс оношилгоо судлалд 17, мэс засал судлалд 18, мэдрэл судлалд 9, эрчимт | - | Сургалтын эрхийг нэмж авах боломжтой | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | амжилттай төгсөж, 86 резидент эмч анги дэвшин суралцсан. 2022-2023 оны хичээлийн жилд 43 эмч ЭМС-ын 2022 оны А\489 дүгээр тушаалаар элсэн суралснаар нийт 127 резидент эмч Дотрын анагаах судлал, Дүрс оношилгоо судлал, Мэс засал судлал, Мэдрэл судлал, Эрчимт эмчмлгээ судлал, Яаралтай 11 тусламж судлал нийт 6 чиглэлийн үндсэн мэргэшлийн сургалтад сургалтад суралцаж байна. | | эмчилгээ судлалд 4 нийт 86 резидент эмч суралцаж байна. Одоогийн байдлаар нийт 124 резидент эмч суралцаж байна. | | | |
| 2. | Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төвд зайн сургалт явуулах боломжийг бүрдүүлж, зайн сургалтын чиглэлийг өргөжүүлж, оролцогчдын тоог нэмэгдүүлэх | Зайн сургалтын төвтэй эсэх, зохион байгуулсан сургалтын чиглэл, тоо | Үндэсний оношилгоо эмчилгээний төв болон өргөжиж, лавлагаа тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж байгаа тул бусад төрөлжсөн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, ӨЭМТ, СЭМТ-ийн эмч нарт зориулсан 10 удаагийн багц цагийн сургалтыг танхим, цахим хосолсон хэлбэрээр | Зайн сургалтыг зохион байгуулах | - Тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэлээр 10 удаагийн багц цагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 450 гаруй эмч, сувилагч, тусгай мэргэжилтэнг хамруулаад байна.<br>- Зүүн бүсийн 5 аймгийн Нэгдсэн эмнэлэг, БОЭТ болон алслагдсан 3 дүүргийн Эрүүл мэндийн төвтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд ахисан түвшний 10 багц цагийн сургалтыг виртуал, цахим хэлбэрээр зохион байгуулж давхардсан тоогоор 300 гаруй хөдөө, орон нутгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг хамруулсан. | УХТЭ-т сургалтад хэрэглэж байгаа зүүмийн оролцогчдын тоо 100 хүний багтаамжтай байгаа учраас оролцогчдын тоо хязгаартай байна. | Сургалтын тоог нэмэгдлүүлэх боломжтой | Олон хүнийг хамруулах боломж байхгүй байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2022 онд зохион байгуулсан. | | | | | |
| 3. | Зайн сургалтын хэрэгцээнд үндэслэн сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтанд зайн сургалтыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах | Сургалтын төлөвлөгөө, Тайлан, хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | Санамж бичиг байгуулсан зүүн бүсийн 5 аймаг, алслагдсан 3 дүүргийн 700 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн ахисан түвшний сургалтад хамрагдсан байна. | Зайн сургалтыг зохион байгуулах | Зүүн бүсийн 5 аймгийн Нэгдсэн эмнэлэг, БОЭТ болон алслагдсан 3 дүүргийн Эрүүл мэндийн төвтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд ахисан түвшний 10 багц цагийн сургалтыг виртуал, цахим хэлбэрээр зохион байгуулж давхардсан тоогоор 300 гаруй хөдөө, орон нутгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг хамруулсан. | УХТЭ-т сургалтад хэрэглэж байгаа зүүмийн оролцогчдын тоо 100 хүний багтаамжтай байгаа учраас оролцогчдын тоо хязгаартай байна. | Сургалтын тоог нэмэгдлүүлэх боломжтой | Олон хүнийг хамруулах боломж байхгүй байна. |
| 4. | Улс, орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөр, байгууллагын санхүүжилтээр гадаадын өндөр хөгжилтэй оронд эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах тоог нэмэгдүүлэх | Өндөр хөгжилтэй оронд сургалтад хамрагдсан эмч, сувилагч, мэргэжилтэн | Мэдрэлийн мэс заслын тасгийн эрхлэгч М.Тэмүүжин ХБНГУ-д тархины дурангийн мэс заслын сургалтанд, Ангиографийн тасгийн эрхлэгч В.Гантулга БНСУ-д Мэдрэлийн судасны мэс заслын мастер класс сургалт, Мэдрэлийн мэс заслын тасгийн эмч Э.Анхбаяр Австри улсад Нурууны мэс заслын сургалт, БНСУ-д нуруу нугасны мэс заслын сургалт, 2022 онд ЭМС-ын А\185 дугаар тушаалаар баталсан "Гадаадын өндөр | Улс, орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөр, байгууллагын санхүүжилтээр гадаадын өндөр хөгжилтэй оронд эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулах тоог нэмэгдүүлэх | - 2023 оны эхний хагас жилийн байдлаар БНСУ, Япон, Канад, БНФУ, АНУ, Казакстан, Вьетнам зэрэг орнуудад нийт 34 эмнэлгийн эмч, мэргэжилтэнг урт болон богино хугацааны сургалт, олон улсын хурал, конференцид оролцсон.<br>- Мэдрэлийн мэс заслын чиглэлээр- 1 эмч, Хүүхдийн мэдээгүйжүүлгийн мэргэжил дээшлүүлэх сургалт-1 эмч, Гемодиализийн мэргэжил дээшлүүлэх сургалт-1 эмч, Хүүхдийн эрчимт эмчилгээний мэргэжил дээшлүүлэх сургалт-1 эмч хамрагдсан.<br>- ЭМХТ-ийн захирлын “Гадаад сургалтын төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А\38 дугаар тушаалаар ЗССТ-ийн ангиографийн баг “Зүрхний хавхлага солих судсан дотуур мэс засал” сургалтад, Тайвань улсын NTUH-д Хавдар судлал, эрчимт, мэдээгүйжүүлэгийн | - | УХТЭ нь гадаад орнуудтай байгуулсан санамж бичгийн хүрээнд гадаадын өндөр хөгжилтэй оронд эмч, мэргэжилтэнг сургах бүрэн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжийг судалж байна. | Гадаад сургалтад зарцуулах төсөв хүрэлцэхгүй байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжилтэй оронд сургах тэргүүлэх чиглэл"-ийн дагуу "Зүрхний хавхлага солих судсан дотуурх мэс засал" чиглэлээр Зүрх судас судлалын тасгийн эмч Б.Батболд, Д.Амарзул, сувилагч Д.Батцэцэг нар БНСУ-д Ёонсей их сургуулийн Северенс эмнэлэгт, Гэмтэл согог, ортопедийн тасгийн зөвлөх эмч Б.Батзориг Канад улсад өвдөг түнхний хиймэл үений халдварын дараах давтан мэс заслын сургалтад, БНСУ-ын Олон Улсын Эрүүл Мэндийн Сангийн ^г±ее ^опд Моок-ын тэтгэлэгт сургалтад Цөмийн оношилгоо, эмчилгээний РЕТ/СТ хариуцсан инженер О.Тэмүүлэн, Цацраг идэвхит эмийн үйлдвэрлэлийн технологич Т.Уянга, Цөмийн онош зүйн эмч Э.Мандуул, уушги судлалын тасгийн эмч | | нийт 3 эмч 3-р улиралд суралцахаар бэлтгэл ажлыг хангасан. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Д.Бямбадолгор, яаралтай тусламжийн тасгийн эмч Г.Янжинлхам нар, Мэдрэл судлалын тасгийн эмч Д.Уянга БНСУ-д мэдрэл судлалын сургалтад, Ерөнхий мэс заслын тасгийн эмч Б.Ган-Эрдэнэ, Н.Тайван нар БНСУ-д нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс заслын сургалтад хамрагдсан | | | | | |
| 5. | Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа бага эмч, эх баригч, сувилагч нараас тухайн орон нутагт дутагдалтай байгаа их эмчийг захиалгаар бэлтгэх | Бэлтгэгдсэн их эмчийн тоо | | | Хамааралгүй | | | |
| 6. | Сум, сум дундын болон багийн эмнэлэгт 3 жил тогтвор суурьшилтай ажилласан эрэгтэй эмчийг цэргийн дүйцүүлэх албыг хаасанд тооцож, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэх чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах | Цэргийн дүйцүүлэх албыг хаасан эрэгтэй эмчийн тоо | | | Хамааралгүй | | | |
| 7. | Сувилагч, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа бусад эмнэлгийн их эмч, | Мэргэжил дээшлүүлэх сургалтад | Төгсөлтийн дараах сувилахуйн төрөлжсөн болон дээшлүүлэх сургалтад нийт 28 сувилагч | Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад | Сувилахуйн Мэргэжил дээшлүүлэх сургалтад:<br>1. Дурангийн онош зүй-8 сувилагч<br>Төрөлжсөн мэргэшлийн сургалт | - | Сургалтыг 5 чиглэлийг нэмэгдүүлж авах боломжтой | сургалтын нэгдсэн хөтөлбөр хүлээгдэж байгаа |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бага эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэнг улсын тсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад түлхүү хамруулах | хамрагдсан сувилагч, сум тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа бусад эмнэлгийн их эмч, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний тоо | суралцснаас төрийн сангийн зардлаар 13 сувилагч суралцсан. Үүнд:<br>• Дархлаажуулалтын сувилахуй-1.<br>• Мэдрэлийн сувилахуй-1<br>• Мэс заслын сувилахуй-10<br>• Эрчимт эмчилгээний сувилахуй-3<br>• Яаралтай тусламжийн сувилахуй-5<br>• Мэдээгүйжүүлгийн сувилахуй-3<br>• Оношилгооны дурангийн сувилахуй-5<br>Сургалтын хугацаанд үндсэн цалинг 100% олгосон. | түлхүү хамруулах | 1. Мэс заслын сувилахуй-11 сувилагч<br>2. Мэдээгүйжүүлгийн сувилахуй-4 сувилагч<br>3. Эрчимт эмчилгээний сувилахуй-5 сувилагч<br>4. Яаралтай тусламжийн сувилахуй-5 сувилагч суралцаж байна<br>Өөрийн эмнэлгийн 12 сувилагч суралцаж байгаагаас:<br>1. Эрчимт эмчилгээний сувилахуй -4<br>2. Мэс заслын сувилахуй -4<br>3. Мэдээгүйжүүлгийн сувилахуй -2<br>4. Дурангийн онош зүй-1<br>5. Яаралтай тусламжийн сувилахуй - 1 суралцаж үүнэс 4 сувилагч төрийн сангаар суралцаж байна. | | Цаашид мэс засал, эрчимт эмчилгээний сувилахуйн чиглэлээр дотоодоос сургах тоог нэмэгдүүлэх | |
| 8. | Их эмчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийн сургалтыг өргөжүүлэн эмнэл зүйн чиглүүлэгч багшийн тоог нэмэгдүүлж, сувилахуйн мэргэшүүлэх сургалтыг удирдах сувилагч-сургагч байгшийг үе шаттайгаар бэлтгэж эхлэх | Их эмч болон сувилагчийн мэргэшүүлэх сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийн тоо | Эмнэлзүйн сургагч багшаар 6 эмч, 1 эм зүйч, 1 сувилагчийг шинээр бэлтгэснээр УХТЭ-т нийт 38 эмнэлзүйн сургагч багштай болсон байна. | Шаардлага хангасан эмч, сувилагч нарыг төгсөлтийн дараах сургалт удирдах эмнэлзүйн сургагч багшийн сургалтад хамруулах | - Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтыг удирдан зохион байгуулах эмнэлзүйн сургагч багшийн шалгуурыг хангасан 24 эмчийн мэдээллийг ЭМХТ рүү хүргүүлсэн. Тус эмч нарыг 2023 онд эмнэлзүйн сургагч багшийн сургалтад хамруулахаар ЭМХТ-ийн сургалтын төлөвлөгөөнд оруулж баталсан.<br>- Сувилахуйн эмнэлзүйн сургагч багш 12 ажиллаж байгаа. Байгууллагын зардлаар | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 24 сургагч багшийг бэлтгэхээр захиалгаа өгсөн 9 сард сургалтаа зохион байгуулна. | | | |
| 9. | Лавлагаа шатлалын эмнэлгийн эмч, мэргэжилтнийг анагаах ухааны судалгааг бүрэн эхээр нь ашиглах боломжийг бүрдүүлэх | Анагаах ухааны судалгааг бүрэн эхээр нь ашиглах эрх, боломж | УХТЭ-ийн эмч нар https://www.uptodate.com/contents/medical сайтнаас АУ-ны зарим судалгааг бүрэн эхээр нь судалж байна. | **“Up-To-Date”** платформын тогтмол ашигладаг мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх | - Эмч нар https://www.uptodate.com/contents/medical сайтнаас АУ-ны зарим судалгааг бүрэн эхээр нь судалж байна.<br>- ЭМХТ-өөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, нотолгоонд суурилсан анагаах ухааныг оношилгоо, эмчилгээнд өргөнөөр ашиглах, UpToDate цахим платформын хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн цахим сургалт зохион байгуулах тул эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. | Гадаадын өндөр хөгжилтэй орны АУ-ны судалгааг ашиглаж болдог бусад сайтнууд руу нэвтэрч орох эрхийн төлбөрийг төлөөгүй тул ашиглах боломжгүй байна. | Эмнэлэг гадаад хамтын ажиллагааны хүрээнд зарим сайт руу нэвтэрч орох боломжийг судалж байна | - |
| 10. | Эрүүл мэндийн байгууллагад ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах нийтлэг журмыг баталж мөрдүүлэх | Батлагдсан журам; Журмын хэрэгжилт | - "Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.<br>- Эмнэлгийн ЦАХИМ хуудасны "АЖЛЫН БАЙРНЫ ЗАР” буланд 132 удаа нийт 48 ажлын байрны зар, эмнэлгийн Расеьоок раде-д 81 удаа 48 ажлын байрны зарыг байршуулсан | Батлагдсан орон тоонд ажилтныг ажилд авах, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах | - “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам”-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан.<br>- 2023 оны 06 дугаар сарын байдлаар нийт 27 ажлын байранд 67 удаа сонгон шалгаруулах зарыг эмнэлгийн вэб хуудас, эмнэлгийн фейсбүүк фейж, ЭМХТ-ийн программд ил тод байршуулсан. 2023 оны 06 | Үйлчлэгч болон сувилагчийн ажлын байрны зар хамгийн их зарлагдсан боловч сул орон тоо их байна. | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд 3 ажлын байрны захиалга өгсөн.<br>- Монгол Улсын хэрэгжүүлэгч агентлаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн н.Дорждэрэмтэй хамтран ажиллаж үйлчлэгч, цахим бүртгэл лавлагааны ажилтны ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах санал, хүсэлтийг хүргүүлсэн<br>- Ажилд орохыг хүссэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг Эмнэлгийн Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан "Сонгон шалгаруулах журам"-ын дагуу Удирдлагын зөвлөлийн хурал болон тасгийн хамт олны хурлаар | | дугаар сарын байдаар нийт 63 эрүүл мэндийн ажилтан шинээр ажилд орсон. Үүнээс 16 эмч, 22 сувилагч, туслах сувилагч, 12 үйлчлэгч, 13 бусад ажилтнууд байна.<br>- https://info.shilendans.gov.mn/ “Шилэн данс”-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.<br>- 04 дүгээр сарын 14-ний өдөр Этүгэн их сургууль, 04 дүгээр сарын 21-ний өдөр АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн төгсөх дамжааны оюутнуудтай ажил олгогчдын нэгдсэн уулзалт арга хэмжээнд оролцож шинэ төгсөх сувилагч нарт эмнэлгийн давуу тал, хөгжих бололцоо зэргээр танилцуулга хийж, сувилагчаар ажиллах урилга өгсөн.<br>- 04 дүгээр сарын 27-ний өдөр Дархан-уул аймгийн анагаах ухааны сургуулийн ажил олгогч,төгсөгчдийн уулзалтанд байгууллагаа сурталчилах, сувилахуйн хүний нөөцийн бүрдүүлэлт хийх зорилготой оролцож бакалаврын 10, дипломын 4 оюутанд ажлын байрны батламж гардуулсан. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэлэлцүүлсний үндсэн дээр ил тод, нээлттэйгээр сонгон шалгаруулж ажилд авч, 2022 онд 113 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан | | | | | |
| 11. | Эрүүл мэндийн байгууллага бүр шинэ ажилтныг хамт олонд танилцуулах, ажлын байранд дадлагажуулах сургалтыг зохион байгуулж хэвших | Ажлын байрны сургалтын хөтөлбөр; хамрагдсан ажилтны тоо | УХТЭ-т шинээр ажилд орсон эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнд эмнэлгийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, хөдөлмөрийн дотоод журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, халдварын сэргийлэлт зэрэг сэдвийн хүрээнд зааж, чиглүүлэх зорилготой сургалтыг 09 дүгээр сарын 06-ны 18 өдөр Захиргаа, хүний нөөцийн алба, Сургалт гадаад харилцааны алба, Сувилахуйн алба хамтран зохион байгууллаа. Тус сургалтад шинээр ажилд орсон нийт 18 хүн хамрагдсан бөгөөд | Шинэ ажилтныг хамт олонд танилцуулах, ажлын байранд дадлагажуулах сургалтын шинэ хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах | - 2022-2023 оны хичээлийн жилд шинээр элсэн суралцсан 563 эмч, 28 сувилагчид 3 хоног чиглүүлэх сургалтад хамруулсан.<br>- Мөн 2022 оны 6 дугаар сараас 2023 оны 5 сар хүртэлх шинээр орсон эмч, эрүүл мэндийн ажилтны дунд халдвараас сэргийлэх хяналт, ipsg 6 зорилтын талаар сургалт 2023 оны 04 дүгээр сарын 25,27 5 дугаар сарын 2-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 70 шинээр орсон эрүүл мэндийн ажилтанд сургалт хийсэн.<br>- 2023 оны 02 дугаар сарын 16 өдөр шинээр ажилд орсон үйлчлэгч, сувилагч, сувилагчийн туслах нийт 22 эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан.<br>- 2023 оны 04 дүгээр сарын 13 өдөр нийт хангамж үйлчилгээний ажилтан, шинээр орсон сувилагч нар нийт 44 эрүүл мэндийн ажилтанд сургалт зохион байгуулсан.<br>- Сувилахуйн албанаас туслах сувилагчаар ажиллаж буй 14 оюутанд байгууллагын танилцуулга, тасаг нэгжийн онцлог, ажил үүргийн | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 12 сэдвийн хүрээнд ажил үүргээ гүйцэтгэхэд нэн шаардлагатай анхан шатны мэдлэг, мэдээллээ бүрэн олж авсан байна. | | хуваарийн талаар 2023 оны 03 сард зохион байгуулсан | | | |
| 12. | Байгууллага нь ажилтан бүрийн ойрын болон дунд хугацаанд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу ур чадвар, туршлагыг үнэлж, тэднийг сургах, хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлэх | Ажилтнуудын 70-аас доошгүй хувь нь жил бүр ур чадвараа хөгжүүлэх сургалтад хамрагдсан байх | - Эмнэлгийн удирдах албан тушаалтнуудын харилцаа хандлага, байгууллагын соёлыг дээшлүүлэх, удирдах ёс зүй манлайллыг сайжруулах зорилготой сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 11-ний өдөр "Тайж ресорт" хурлын танхимд зохион байгуулсан.<br>- 2022 оны 4 дүгээр сарын 8-нд АУ-ны доктор, сэтгэл заслын эмч, сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэгийн нарийн бичгийн 19 нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлэх дарга | Ажилтнуудын 70-аас доошгүй хувь нь жил бүр ур чадвараа хөгжүүлэх сургалтад хамрагдсан байх | - Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 5 дугаар зорилтын хүрээнд эрүүл мэндийн ажилтныг чадавхижуулах талаар 2023 оны эхний улиралд хэвтэн болон хэвтэн бус тасгуудын дунд халдвар хяналт болон эмнэлгийн тусламж үйлчилгээ аюулгүй байдлын чиглэлээр нийт 24 тасаг нэгжүүд дотоодоо сургалт зохион байгуулсан.<br>- 12 тасаг нэгжүүд халдварын сэргийлэлт хяналт болон эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын чиглэлээр видео шторк эмнэлгийн цахим хуудсанд байшуулан хэвтэн эмчлүүлэх тасгуудаас "Зүрх судас судлалын тасаг нэгдүгээр байр", хэвтэн бус тасгуудаас "Нэгдсэн лабораторийн тасаг" тус бүр нэгдүгээр байрт шалгарсан.<br>- Жайка олон улсын байгууллагатай хамтран сувилагчийн цогц чадамжийн 2 удаагийн сургалт зохион байгуулсан. | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Н.Алтанзул "Стресс менежмент ба харилцаа" сэдвээр нийт эмч нарт лекц уншсан.<br>- 2022 оны 4 дүгээр сарын 22-нд Монгол Кампус Крусейд фор Крайст байгууллагын эмч, сувилагч, эмч нарын салбарын удирдагч Д.Төгөлдөр эмнэлгийн нийт эмч нарт "Бид харилцаанд бэлэн үү" сэдэвт хувь хүний хөгжлийн лекц уншсан.<br>- Эрдэм шинжилгээ, инноваци, хөгжлийн бодлого хариуцсан дэд захирал Д.Цогт-Очир 2022 оны 5 сарын 12, 20-ны өдрүүдэд эмнэлгийн мэргэжилтнүүдэд "Байгууллагын соёл, харилцаа" сэдвээр лекц уншсан. | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - Төлөвлөгдсөн өглөөний сургалтууд бүрэн зохион байгуулагдсан байна. Төв, эмнэлзүйн тасгууд 03 сараас эхлэн долоо хоног бүрийн пүрэв гариг бүрд "Өглөөний хэлэлцүүлэг" хийж байна. Одоогоор 25 удаа тасгууд өглөөний хэлэлцүүлэг хийсэн байна. | | | | | |
| 13. | Эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургах, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан шатлалын эмнэлэгт сэлгэн ажиллуулах | Ажиллас ан эмнэлгий н мэргэжил тний тоо | - Зүүн бүсийн таван аймаг болох Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь болон Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануур, Налайх, Багахангай дүүргийн Нэгдсэн эмнэлгүүдтэй гурван жилийн хугацаатай санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн зүүн бүсийн 5 аймаг, алслагдсан 3 дүүргийн 700 гаруй | ажлын байранд дадлагажуулан сургах, төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнийг бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг болон анхан | - Ховд аймгийн Нэгдсэн эмнэлгийн тогооч 3-р сард 14 хоногийн хугацаатай Хоол шим тэжээлийн тасагт дадлага сургалтад хамрагдсан.<br>- Багануур дүүргийн ЭМТ-ийн мэдрэлийн эмч нар Харвалтын тасагт 4-р сард дадлага хийсэн.<br>- Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдээгүйжүүлэгийн эмч 4-р сард Өвдөлт намдаах кабинетад 14 хоногийн эмнэлзүйн дадлага сургалтад хамрагдсан.<br>- Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч, Налайх дүүргийн ЭМТ-ийн мэс заслын эмч дурангийн мэс | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн ахисан түвшний сургалтад хамрагдсан байна<br>- Зүүн 5 аймаг, алслагдсан 3 дүүрэгт 3 долоо хоногийн турш 3 багаар 30 гаруй эмч, мэргэжилтнүүдийнхээ хамт 4000 км гаруй урт замыг туулан хамтарсан сургалт, хамтарсан хагалгаа, телемедициний холболт гэсэн ажлуудыг төлөвлөн ажиллаа.<br>- Орон нутгийн 300 орчим эмч мэргэжилтнүүдэд 8 төрлийн мэдлэг олгох лекц уншснаас гадна 20 гаруй ахисан түвшний хагалгааг амжилттай хамтран хийлээ.<br>- Багануур дүүргийн ЭМТ-ийн чанарыг баг 14 хоногийн дадлага сургалтыг УХТЭ-т хийсэн.<br>- Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн дүрс | шатлалын эмнэлэгт сэлгэн ажиллуулах | заслын мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтад хамрагдсан.<br>- Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн удирдлага, эмч нар нийт 15 хүн, Баянхонгор аймгийн Өрхийн эрүүл мэндийн төвийн 24 эмч, сувилагч нар, мөн Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвийн Мэдрэл судлалын тасгийн 2 эмч, 3 сувилагч нарын бүрэлдэхүүнтэй хөдөө, орон нутгийн төлөөлөгчид 2023 оны 04-р сарын 07-27-ны өдрүүдийн хооронд тус эмнэлэгт зочилж, Үндэсний оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцлаа.<br>- 2023 оны 06 дугаар сарын 07-нд Дорнод аймгийн БОЭТ-ийн эмч нарын баг манай эмнэлгийн эмнэлзүйн зохицуулалт, статистик, чанар, хүний нөөц, МЭЭТ, мэс засал, хүүхэд зэрэг алба тасгийн үйл ажиллагаатай танилцлаа.<br>- Зүрх судас судлалын тасгийн хамт олон 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Төв аймгийн Батсүмбэр суманд байрлах ахмад настаны үндэсний төвд ажиллан 10 эмч 2 сувилагчийн бүрэлдэхүүнтэй баг 110 ахмад настанд зүрхний эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийж, эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн.<br>- Мэдрэл судлалын тасгаас 2023 оны 06 дугаар сарын.10-ны өдөр Архангай аймгийн Тариат сумын Асгат /Алтаад/ багт ажиллалаа. Асгат | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оношилгооны эмч дурангийн оношилгооны 21 хоногийн эмнэлзүйн дадлага сургалтыг УХТЭ-ийн Дурангийн төвд хийж байна. | | багийн 32 малчинд багийн эмч хамт нарийн мэргэжлийн мэдрэлийн эмчийн үзлэг оношилгоо хийж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч харвалтын эрсдлийг тодорхойллоо. Тархины харвалт үүсэх өндөр эрсдэлтэй 6 малчинг илрүүлж дэлгэрэнгүй зөвлөгөө өглөө. | | | |
| **Гурав.Санхүүгийн болон санхүүгийн бус урамшууллын шинэ аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэх** | | | | | | | | |
| 1. | Эмнэлгийн мэргэжилтний хөдөлмөрийн норм, нормативыг тооцох аргачлалыг холбогдох байгууллагатай хамтран шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах | Батлагдсан аргачлал | 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан А/185, А/252 тушаалын дагуу Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал тооцох, хөдөлмөрийн норм, норматив тогтоох тухай аргачлыг судалсан | Эмнэлгийн мэргэжилтний хөдөлмөрийн норм, нормативыг тооцох аргачлалын дагуу норм, нормативыг тооцох | Дүрс оношилгооны төвийн дарга, радиологийн тасгийн эрхлэгч, эмч, рентген техникчийн ажлын гүйцэтгэлийн (Соронзон резонанст томографи, компьютер томографийн шинжилгээ) норм норматив тогтоох тухай журмыг 2023 оны 04 дүгээр сарын 19-нд Ерөнхий захирлын А/44 дүгээр тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна | - | - | - |
| 2. | Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг боловсронгуй болгох | Эмч, эмнэлгийн ажилтны урамшуулал авсан тоо, мөнгөн дүн | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур | Гүйцэтгэлийн үнэлгээний дагуу олгосон урамшууллыг олгосон байна. | - Эмнэлгийн алба, төв, тасаг, хэсгийн дарга эрхлэгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн арга, аргачлалаар хангах удирдах албан тушаалтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор алба, төв, тасаг, хэсгийн удирдах албан тушаалтнуудын ажлын үр дүнгийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг ерөнхий захирлын 2023 оны А/60 дугаар тушаалаар баталсан. | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2022 оны I улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 180,327,968 төгрөг, 2022 оны II улиралд 509 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 191,285,364 төгрөг, 2022 оны III улиралд 506 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 165,355,960 төгрөг, олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2022 оны Б/164, Б/249, А/104 тушаалууд) | | - Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2023 оны I улиралд 513 эмнэлгийн эрүүл мэндийн ажилтанд 257,541,184 төгрөг, II улиралд 504 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 273,498,056 төгрөг олгогдсон. | | | |
| 3. | Эрүүл мэндийн ажилтны нэмэгдэл хөлсний талаар мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх | Дотоод аудитын тайлан | Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоол болон бусад эрх зүйн баримт бичгийн дагуу нэмэгдэл хөлсийг тооцон олгосон. | Хууль, дүрмийн дагуу дотоод аудит хийсэн байна. | - Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 22.1 дэх заалтын дагуу эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 12, Зөвлөх эмч-6, Зөвлөх сувилагч-2, Тэргүүлэх эмч -30, Тэргүүлэх сувилагч-46, Ахлах эмч 23, Ахлах сувилагч 63, бусад мэргэжилтэн 182 нийт ажилтанд боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооцон 141 226 208 төгрөгийн нэмэгдэл олгосон<br>- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нийт 382 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 297,289,230 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 31 ажилтанд 10%-иар тооцон нийт 20,417 220 төгрөг тооцон олгосон. | | | |
| 4. | Өндөр өртөгтэй болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогын тодорхой хувийг тухайн тусламж, үйлчилгээг үзүүлсэн эмч, мэргэжилтнүүдэд олгох эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлэх | Эмнэлгийн мэргэжилтэнд олгосон урамшууллын хэмжээ | Өндөр өртөгтэй болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогын тодорхой хувийг тухайн тусламж, үйлчилгээг үзүүлсэн эмч, мэргэжилтнүүдэд олгох эрх зүйн орчин байхгүй Холбогдох эрх зүйн орчин бүрдвэл хэрэгжүүлэн ажиллана. | Өндөр өртөгтэй болон төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогын тодорхой хувийг тухайн тусламж, үйлчилгээг үзүүлсэн эмч, мэргэжилтнүүдэд олгох эрх зүйн орчин байхгүй Холбогдох эрх зүйн орчин бүрдвэл хэрэгжүүлэн ажиллана. | Хууль эрхзүйн орчин байхгүй учир судалгааны шатанд байгаа. | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Эрүүл мэндийн байгууллага ажилтнууддаа зориулж, орон сууцны жишиг хотхон, хорооллыг барьж, байгуулахыг дэмжин газар, дэд бүтцийн хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн засаг, захиргааны байгууллага, бусад төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах | Хэрэгжилт | - 2022 онд эмнэлгийн дэргэдэх хүүхдийн цэцэрлэгт 60 гаруй ажилтнууд, резидент эмч нарын хүүхдүүд хамрагдаж байна. | Эрүүл мэндийн байгууллага ажилтнууддаа зориулж, орон сууцны жишиг хотхон, хорооллыг барьж, байгууллахыг дэмжин газар, дэд бүтцийн хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн засаг, захиргааны байгууллага, бусад төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллана. | - Эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хороо “5 сая төгрөгийн урьдчилгаа бэлдэж орон сууцны зээл хамрагдах боломж” сэдэвт хэлэлцүүлгийг 2023 оны 04 дүгээр сарын 13-нд зохион байгуулж, орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй ажилчдад зориулж баригдаж байгаа, ашиглалтад орсон нийт 4 орон сууцны компаний дэлгэрэнгүй танилцуулгыг ажилтнуудын дунд шат дараатай хийсэн.2023 оны хагас жилийн байдлаар 3 ажилтан орон сууцандаа орсон, 8 ажилтан ипотекийн зээлийг судлуулах шатанд явж байна.<br>- 2023 онд эмнэлгийн дэргэдэх хүүхдийн цэцэрлэгт 60 гаруй ажилтнууд, резидент эмч нарын 75 хүүхэд хамрагдаж байна. | - | - | - |
| 6. | Зээл хүссэн эрүүл мэндийн ажилтанд бага хүүтэй цалингийн болон хэрэглээний зээл олгоход банк, санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах | Бага хүүтэйцалингийн болон хэрэглээний зээл авсан эрүүл мэндийн ажилтны тоо | - Худалдаа хөгжлийн банкны сансар салбартай хамтран орон сууцны 6%-ийн зээл болон цалингийн багц бүтээгдэхүүний талаар өдөрлөгийг 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр эмнэлэг дээрээ зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр 115 ажилтанд орон сууцны зээлийн | Зээл хүссэн эрүүл мэндийн ажилтанд бага хүүтэй цалингийн болон хэрэглээний зээл олгоход дэмжлэг үзүүлэх | Арилжааны банкуудтай хамтын гэрээ байгуулан цалингийн зээлийг 1.2% болгон цалин авах дансыг тухайн банканд байршуулах ажил хийгдэж байна. | 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс Монгол банк бодлогын хүүгээ нэмсний улмаас цалингийн зээлийн хүү 1,5% болсон. | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвөлгөө, 20 ажилтанд банкны карт захиалгын үйлчилгээ үзүүлсэн - 2022 онд эмнэлгийн ажилтны хэрэглээний зээлийн баталгааг баталгаажуулах зорилгоор ХАС банктай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу 317 эмнэлгийн мэргэжилтэн, 24 болон хэрэглээний зээл о лгоход банк, санхүүгийн байгууллагатай хэрэглээний хамтран ажиллах ажилтанд 2,185,000,000 төгрөгийн цалингийн зээл олгоход байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлсэн. | | | | | |
| 7. | Эрүүл мэндийн ажилтны төрсөн аав, ээж, эхнэр (нөхөр), үр хүүхэд зэрэг гэр бүлийн аль нэг гишүүнд жилд нэг удаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх боломжийг судлан, шийдвэрлэх | Гэр бүлийн гишүүдийн тоо | - Монгол улсын хөдөлмөрийн баатар, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ахмад ажилтан, 75-с дээш настай ахмадуудад хэвтэн эмчлүүлэхгүйгээр, яаралтай бус журмаар амбулаторийн үзлэг, оношилгоо, | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай ажилтан, түүний гэр бүлд тусламж үйлчилгээг үзүүлэх | - 2022 оны 10 дугаар сарын 25-нд Хөдөлмөрийн баатар, 80-с дээш насны ахмад настан болон эмнэлгээс тэтгэвэрт гарсан ахмад настанд хүлээгдэл, дараалалгүй, хүртээмжтэй үйлчлэх, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор Дотрын 2 гэсэн кабинетийн үйл ажиллагааг эхлүүлж, нэг эмч томилон ажиллуулж байгаа. 2023 оны хагас жилийн хугацаанд тухайн | - 2022 оны 4 дүгээр сараас эхлэн амбулаторийн эмнэлгийн хуудсыг эмнэлгийн үйлчлэх хүрээний жагсаалта | Эмнэлгийн ажилтнууд болон түүний гэр бүлийн гишүүдийг эмнэлгийн үйлчлэх хүрээнд оруулж шинэчлэн батлуулж амбулатор иор | Эрүүл мэндийн сайдын баталсан “Эмнэлгийн үйлчлэх хүрээний жагсаалт”-д эмнэлгийн ажилтан болон түүний гэр бүлийн гишүүдийг оруулж |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эмчилгээ, зөвлөгөө, хяналт болон эрүүл мэндийн боловсрол олгох дотрын эмчийн үзлэгийн кабинетыг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс нээн ажиллуулж байна. (Эмнэлгийн ерөнхий захирлын А/116 дугаар тушаал)<br>- Хүүхдийн тасаг нь эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны 448 хүүхдэд амбулатори болон стационарийн тусламж үзүүлсэн ба үүнээс 98 нь стационарийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Мөн түүнчлэн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны 0-2 насны 39 хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан | | кабинетаар 343 хүн үйлчлүүлсэн байна.<br>- Хүүхдийн тасаг нь эмнэлгийн мэргэжилтэн ,ажилтны 214 хүүхдэд амбулатори болон стационарийн тусламж үзүүлсэн ба 46 нь стационарийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн түүнчлэн эмнэлгийн мэргэжилтэн ажилтны 0-2 насны 40 хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан | д багтаагүй ажилтнуудад олгохгүй болсон. | үзүүлэх болон хэвтэн эмчлүүлэх эд боломжоор хангах | шинэчлэн батлуулах |
| **Дөрөв. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжин, оролцогч талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | | |
| 1. | Эрүүл мэндийн ажилтнуудын тоо, байршил, хуваарилалт, хүртээмж, төгсөлтийн дараах сургалтанд хамрагдалт, шилжилт хөдөлгөөний статистик мэдээллийг боловсронгуй болгох | Хүний нөөцийн мэдээний нэгдсэн сангаас гаргасан статистик мэдээлэл , | - 2022 онд 28 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байрны зохицуулалт хийж, түр болон урт хугацаагаар сэлгүүлэн, | Эрүүл мэндийн ажилтнуудын тоо, байршил, хуваарилалт, хүртээмж, төгсөлтийн дараах сургалтад | - 2023 оны эхний хагас жилд 21 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байрны зохицуулалт хийж, түр болон урт хугацаагаар сэлгүүлэн, шилжүүлэн ажиллуулсан. (Ерөнхий захирлын 2023 оны Б/10, Б/11, Б/18, Б/40, Б/42, Б/48, Б/49, | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгэгдсэн ажилтны тоо / нийт ажилтны тоо гэх мэт | шилжүүлэн ажиллуулсан. (Ерөнхий захирлын 2022 оны Б/22, Б/23, Б/51, Б/55, Б/109, Б/121, Б/154, Б/177, Б/220, Б/241, Б/339, Б/354, Б/384, Б/425 дугаар тушаал)<br>- Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. 2020 оны 10 дугаар сараас эхлэн Хүний нөөцийн удирдлагын систем (ХНУС) дэх өгөгдлийн дагуу ажилтнуудын тоо, байршил, хуваарилалтыг тухай бүр шинэчлэн | хамрагдалт, шилжилт хөдөлгөөний статистик мэдээллийг тогтмол шинэчлэж бүртгэнэ. | Б/51, Б/52, Б/53, Б/80, Б/81, Б/82, Б/89, Б/94, Б/102, Б/110, Б/133 дугаар тушаал)<br>- Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. 2020 оны 10 дугаар сараас эхлэн Хүний нөөцийн удирдлагын систем (ХНУС) дэх өгөгдлийн дагуу ажилтнуудын тоо, байршил, хуваарилалтыг тухай бүр шинэчлэн нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна.<br>- 2023 оны жилийн гамшигийн үеийн бэлэн байдлын судалгаа, тоон мэдээллийг шинэчлэн эмнэлгийн гамшгийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулсан<br>- Монгол улсын засгийн газрын тогтоол 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 491 дүгээх тогтоолын дагуу нийт ажилтны төрийн албан хаасан хугацааны нэмэгдэлийг ХНУМТ Цахим системд шинэчлэн оруулсан<br>- Төрөлжсөн эмнэлгийн стандартын дагуу хүний нөөцийн хангалтын судалгааг 2018-2023 оны хагас жилийн судалгааг гаргасан. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна.<br>- Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй сувилагчдын хүний нөөцийн судалгаа, эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн төлөвлөлтийн урьдчилсан судалгааг 2022 оны 8 дугаар сард гарган ЭМЯ-нд хүргүүлсэн<br>- Улаанбаатар хотын авто замын түгжрэлтэй холбоотой эмнэлгийн цэцэрлэг, бага ангийн хүүхдийн судалгаа, эмнэлгийн алба хаагчид ажилд ирэхдээ ямар тээврийн хэрэгслээр ирдэг судалгааг 2022 оны 9 дүгээр сард нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлсэн. | | - Эмнэлэгт ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын 2021-2023 оны тоон мэдээллийг ЭМЯ-нд хүргүүлсэн. | | | |
| 2. | Эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлтэй холбоотой мэдээллийг эрүүл мэндийн албан ёсны статистик мэдээгээр бүртгэдэг болох | мэдээний нэгдсэн санд бүртгэгдсэн ажилтны тоо / нийт ажилтны | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хуулийн дагуу тухай бүр нь олгосон байна. | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл нь нийт 164 (1041 нийт хоногийн) | 2022 оны 4 дүгээр сараас эхлэн амбулаторийн эмнэлгийн хуудсыг | Эмнэлгийн ажилтнууд болон түүний гэр бүлийн гишүүдийг эмнэлгийн үйлчлэх хүрээнд | Эрүүл мэндийн сайдын баталсан “Эмнэлгийн үйлчлэх хүрээний жагсаалт”-д эмнэлгийн ажилтан болон |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоо гэх мэт | сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл нь нийт 504 (3358 нийт хоногийн) эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтанд Ажил олгогчоос 59,505,348 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 34,869,349 төгрөгийн тэтгэмж олгосон | | эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтанд Ажил олгогчоос 33,651,990 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 17,390,601 төгрөгийн тэтгэмж олгосон. | эмнэлгийн үйлчлэх хүрээний жагсаалтад багтаагүй ажилтнуудад олгохгүй болсон. | оруулж шинэчлэн батлуулж амбулаторийор үзүүлэх болон хэвтэн эмчлүүлэхэд боломжоор хангах | түүний гэр бүлийн гишүүдийг оруулж шинэчлэн батлуулах |
| 3. | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааг тогтмолжуулж өргөжүүлэх | Нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааны тайлан | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлийн шаардлагатай "Өрх гэр бүл толгойлсон эмэгтэйчүүдийн судалгаа", "Эрүүл мэндийн ажилтны орон сууцны судалгаа", "Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэлх эрүүл мэндийн ажилтны судалгаа", "Коронавируст | Нийгмийн хамгааллын чиглэлийн судалгааны тайланг тухай бүр шинэчлэн гаргасан байна. | - ЭМТҮЧАБ-ын албанаас улирал бүр эмнэлгийн ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч түүний үр дүнг тооцон ажилладаг. Судалгааг Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07-р сарын 01 өдрийн А/346 тоот тушаал гарсантай холбоотойгоор эмнэлгийн байгууллага нь эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн үнэлгээг байгууллагын онцлогт тааруулан боловсруулан гаргах болсонтой холбоотойгоор 7 бүлэг, 26 асуулттай судалгааны асуумжаар, цахим хэлбэрээр авдаг. 2023 оны 1-р улиралд нийт 290 эмнэлгийн ажилтан хамрагдсан. Үүнээс эмч, эм зүйч-23.2%, сувилагч-22.7%, бусад-54.2% хамрагдан судалгаанд оролцсон. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн | - | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | халдвар /КОВИД-19/-ын халдвараар өвдсөн эрүүл мэндийн ажилтны судалгаа”, "Эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалтын судалгаа”, "Өртөлтийн судалгаа” гэх мэт судалгааг тогтмолжуулсан. | | хамгааллын хүрээнд тус судалгааны 6-р бүлгийн “Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн худалдан авалт, хүрэлцээ хангамж, хэрэглээ ашиглалт хангалттай гэж та дүгнэх үү” гэсэн асуултаар 32.4% нь “Хангалттай”, 48.6% нь “Дунд зэрэг” гэж үзсэн байна. Ажилчдын ажиллах орчин бүрдсэн гэж та үзэж байна уу? гэсэн асуултаар 44.2% нь “Бүрдсэн”, 48.1% нь дунд зэрэг гэж үзсэн байна. “Хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн үйлчилгээний орчин бүрдсэн гэж та үзэж байна уу? Үгүй бол яагаад?” гэсэн асуултаар 51.8% нь “Бүрдсэн”, 44.7% нь “Дунд зэрэг” гэж үзсэн байна. 7-р бүлгийн “Ажилтнуудын нийгмийн хангамж ба халамж ” хэсгийн “Ажилтнуудын нийгмийн хангамж, урамшуулал идэвхжүүлэлт ямар төвшинд байна гэж та үздэг вэ?” гэсэн асуултаар 11.2% нь “Хангалттай”, 45.9% нь “Дунд зэрэг” гэж үзсэн байна. “Таны хувьд урамшуулал идэвхжүүлэлтийн ямар хэлбэрийг илүүд үзэх вэ” гэсэн асуултаар “Цалингийн нэмэгдэл /ур чадвар, үр дүнгийн/” гэсэн хариултыг 57.1%, “Байр, орон сууцтай болох” гэсэн хариултыг 24.7%, | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Ажлын үр дүнг шударгаар үнэлэх” 16.6% нь сонгосон байна. Ерөнхий сэтгэл ханамж “Маш сайн” 7.9%, “Сайн” 55.4%, “Дунд” 33.7%.<br>“Эмнэлгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа”, "Эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалтын судалгаа”, "Өртөлтийн судалгаа” гэх мэт судалгааг тогтмолжуулсан. | | | |
| 4. | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг бүр ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих үйл ажиллагааг орон нутаг, байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх | Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө, биелэлт | 2020 онд эмнэлгийн ерөнхий захирлаар “Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 2020-2023 он” батлуулан хэрэгжүүлж байна. | 2022 онд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 90%-иас доошгүй байх | Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр<br><br>- “Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам”-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан.<br>- 2023 оны 06 дугаар сарын байдлаар нийт 27 ажлын байранд 67 удаа сонгон шалгаруулах зарыг эмнэлгийн вэб хуудас, эмнэлгийн фейсбүүк фейж, ЭМХТ-ийн программд ил тод байршуулсан. 2023 оны 06 дугаар сарын байдаар нийт 63 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эрүүл мэндийн ажилтан шинээр ажилд орсон. Үүнээс 16 эмч, 22 сувилагч, туслах сувилагч, 12 үйлчлэгч, 13 бусад ажилтнууд байна.<br>- https://info.shilendans.gov.mn/ "Шилэн данс"-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.<br>- 04 дүгээр сарын 14-ний өдөр Этүгэн их сургууль, 04 дүгээр сарын 21-ний өдөр АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн төгсөх дамжааны оюутнуудтай ажил олгогчдын нэгдсэн уулзалт арга хэмжээнд оролцож шинэ төгсөх сувилагч нарт эмнэлгийн давуу тал, хөгжих боломцоо зэргээр танилцуулга хийж, сувилагчаар ажиллах урилга өгсөн.<br>- 04 дүгээр сарын 27-ний өдөр Дархан-уул аймгийн анагаах ухааны сургуулийн ажил олгогч,төгсөгчдийн уулзалтанд байгууллагаа сурталчилах, сувилахуйн хүний нөөцийн бүрдүүлэлт хийх зорилготой оролцож бакалаврын 10, дипломын 4 оюутанд ажлын байрны батламж гардуулсан. | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Иргэд болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас байгууллагын хүний нөөцийн удирдлагатай холбоотой гарсан гомдол байхгүй болно.<br>- Шинээр ажилд орсон нийт 64 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан<br>- 2023 оны эхний хагас жилд 21 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байрны зохицуулалт хийж, түр болон урт хугацаагаар сэлгүүлэн, шилжүүлэн ажиллуулсан. (Ерөнхий захирлын 2023 оны Б/10, Б/11, Б/18, Б/40, Б/42, Б/48, Б/49, Б/51, Б/52, Б/53, Б/80, Б/81, Б/82, Б/89, Б/94, Б/102, Б/110, Б/133 дугаар тушаал)<br>- 2023 оны хагас жилийн байдлаар Хөгжлийн бэрхшээлтэй 3 албан хаагч ажиллаж байна<br><br>Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангаж, чадавхийг бэхжүүлэх<br><br>- Зүүн бүсийн 5 аймгийн Нэгдсэн эмнэлэг, БОЭТ болон алслагдсан 3 дүүргийн Эрүүл мэндийн төвтэй байгуулсан | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санамж бичгийн хүрээнд ахисан түвшний 10 багц цагийн сургалтыг виртуал, цахим хэлбэрээр зохион байгуулж давхардсан тоогоор 300 гаруй хөдөө, орон нутгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг хамруулсан.<br>- Сувилахуйн алба ЭМЕЗСХороо хамтран дараах ёс зүйн сургалтыг явуулсан. Амьдралд суурилж суралцахуй ТББ-д УХТЭ -ийн Сувилахуйн албаны (Ёс зүйн салбар хороо)-ны зүгээс “Мэргэжилтэний ёс зүй-Харилцааны ур чадвар 1 багц цагийн сургалтыг УХТЭ-ийн эмч, сувилагч, эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн, ажилтануудад авах хүсэлт илгээсний дагуу тасралтгүй хөгжүүлэх нэн чухал асуудал болж буй эмнэлгийн мэргэжилтний Ёс зүй-Харилцаа хандлагын сургалтыг 2023 оны 02 дүгээр сарын 14-ний 14.00 цагт ҮОЭТ-ийн хурлын танхимд АШУҮИС-ийн БАС-ийн тэнхимийн багш С.Наранчимэг /АУ-ны доктор, профессор/, С.Нармандах /докторант/ нартай хамтран зохион байгуулж нийт 124 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан.Сургалтын үр дүнд эмч, сувилагч, эмнэлгийн ажилтууд биеэ авч яваа байдал, өөрийн бодол, биеийн хэлэмж, үгийн сонгол, дууны | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өнгөөс сэтгэлээсээ хандаж буй эсэхэд анхаарах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид хэрхэн яаж хүрэх зэргээр дадлага онол хосолсон сургалт боллоо. эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд болон үйлчлүүлэгч, БЗД-ийн хамрах хорооны иргэдэд "Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ ба ажлын бүтээмж" сэдэвт 2 багц цагийн сургалтын удирдамжийг Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хяналтын хорооны дарга, ЭМХТ-өөр батлуулан 2023 оны 09 сард хийхээр төлөвлөн ажиллаж байна.<br>- ЭМЯ руу 2024 онд ШУТС-аар санхүүжих Цөм технологийн 3, Шинжлэх ухаан технологийн захиалагт 1 төслийн саналыг хүргүүлсэн.<br>- 2023 оны эхний хагас жилийн байдлаар БНСУ, Япон, Канад, БНФУ, АНУ, Казакстан, Вьетнам зэрэг орнуудад нийт 34 эмнэлгийн эмч, мэргэжилтэнг урт болон богино хугацааны сургалт, олон улсын хурал, конференцид оролцсон.<br>- Мэдрэлийн мэс заслын чиглэлээр- 1 эмч, Хүүхдийн мэдээгүйжүүлгийн мэргэжил дээшлүүлэх | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалт-1 эмч, Гемодиализийн мэргэжил дээшлүүлэх сургалт-1 эмч, Хүүхдийн эрчимт эмчилгээний мэргэжил дээшлүүлэх сургалт-1 эмч хамрагдсан.<br>- ЭМХТ-ийн захирлын “Гадаад сургалтын төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А\38 дугаар тушаалаар ЗССТ-ийн ангиографийн баг “Зүрхний хавхлага солих судсан дотуур мэс засал” сургалтад, Тайвань улсын NTUH-д Хавдар судлал, эрчимт, мэдээгүйжүүлэгийн нийт 3 эмч 3-р улиралд суралцахаар бэлтгэл ажлыг хангасан.<br>- Б.Эрдэнэбулган Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн №14296 дугаар бүхий гэрчилгээг “Хөхний хэт авиан оношилгоо” номын бүтээлээр оюуны өмчийн эрх авсан.<br>- Эмнэлгийн алба, төв, тасаг, хэсгийн дарга, эрхлэгчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх нэгдсэн аргачлалаар хангах, удирдах албан тушаалтны ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор “Эмнэлзүйн төв, алба, тасгийн дарга, эрхлэгч нарын ажлын үр дүн, | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”, “Дэмжих алба, тасгийн эрхлэгч нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг тус тус баталж, 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.<br><br>Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах<br><br>- 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмнэлгийн ажилтан, мэргэжилтний үндсэн цалинг 30%-иар нэмэгдүүлсэн.<br>- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 22.1 дэх заалтын дагуу эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 12, Зөвлөх эмч-6, Зөвлөх сувилагч-2, Тэргүүлэх эмч -30, Тэргүүлэх сувилагч-46, Ахлах эмч 23, Ахлах сувилагч 63, бусад мэргэжилтэн 182 нийт ажилтанд боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус тооцон 141 226 208 төгрөгийн нэмэгдэл олгосон<br>- Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нийт 382 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 297,289,230 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам”-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2023 оны I улиралд 513 эмнэлгийн эрүүл мэндийн ажилтанд 257,541,184 төгрөг, II улиралд 504 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 273,498,056 төгрөг олгогдсон.<br>- Алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэний нэмэгдэл хөлсийг Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу нийт 8 эмнэлгийн мэргэжилтэн ажилтанд 368 586 төгрөг олгосон.<br>- Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 06 дугаар | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоолын хавсралтын дагуу хоол, унааны нэмэгдэл 595,581,000 төгрөгийг 495 ажилтанд олгосон.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 31 ажилтанд 10%-иар тооцон нийт 20,417 220 төгрөг тооцон олгосон.<br>- Хариуцлагын нэмэгдлийг 86 ажилтанд нийт 58 393 280 төгрөг тооцон олгосон. | | | |
| 5. | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын чиглэлээр нэвтрүүлсэн шилдэг санаачлага, үйл ажиллагааг шалгаруулж, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх | Түгээн дэлгэрүүлсэн шилдэг туршлага, үйл ажиллагааны тоо | - Үндэсний үйлдвэрлэгч Анартехс ХХК болон эмнэлэг, эмнэлгийн Үйлвэрчний эвлэлийн хороо хамтран ажилтнуудын хүүхдүүдэд зориулж сурагчийн дүрэмт хувцсыг 20-50% хямдралтай үнээр, 1 сарын хугацаатай хүүгүй зээлээр худалдан авах үзэсгэлэн худалдааг 2022 оны 08 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд эмнэлэг дээрээ зохион байгуулсан.<br>- Улсын Хоёрдугаар төв эмнэлгийн дэргэд 100 хүүхдийн ортой | Түгээн дэлгэрүүлсэн шилдэг туршлага, үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлсэн байна. | - Монгол улсын засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлаж, авлигатай тэмцэх таван үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрөөс Авлигын эсрэг “Нэгдье” аяныг зарласан. Аяны хүрээнд байгууллагын фейсбүүк хуудсын профайл болон ханын зургыг АТГ-аас бэлтгэсэн зурагт хуудсаар сольж, байгууллагын 7 мэдээллийн самбарт 5 төрлийн зурагт хуудас, 7 мэдээлэл сурталчилгааны дэлгэц дээр видео шторкыг байршуулж, үйлчлүүлэгч хамгийн ихээр төвлөрдөг 24 цэгүүдэд 5 төрлийн зурагт хуудсыг байршуулсан.<br>- 2023 оны 01 дүгээр сард Call center буюу цаг захиалгын нэгдсэн төвийг нээсэн. Үйлчлүүлэгч нь дуудлагын | - | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | цэцэрлэг шинээр байгуулагдаж Баянзүрх дүүргийн 50 дугаар цэцэрлэгийн салбар бүлэг болсноор 24 дэх байгууллагын цэцэрлэг болон үйл ажиллагаагаа явуулж байна. Одоо 35 цэцэрлэг нийт 100 гаруй хүүхдийг хүлээн авч, дөрвөн бүлэг, 22 багш, ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.<br>- Байгууллагын дэргэдэх хүүхдийн өндөр өнжүүлэх төв ажиллуухаар ажилтнуудаас судалгаа авсан бөгөөд 54 ажилтны 6-15 насны нийт 74 хүүхэд хамрагдах хүсэлт гаргасан байна.<br>- Мобиком корпорациас байгууллагын мобиком хэрэглэгч бүх ажилтнуудад 2022 оны турш сар бүр 10 гб дата эрхээр урамшууллаа.<br>- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн | | нэгдсэн төвийн 70150222 дугаараар холбогдон амбулаторийн үзлэгийн цагийг товлохоос гадна, Эмчтэй холбогдож анхан шатны эмнэлгийн зөвлөгөө авах боломжтой болсон. Өмнө нь утсаар цаг захиалах үйлчилгээг нэг ажилтан үзүүлдэг байсан бол дээрх төвийг нээснээр иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх таатай нөхцөл бүрдсэн, мөн утсаар цаг захиалахтай холбоотой иргэдээс ирэх гомдол эрс буурсан.<br>- 2023 оны 02 дугаар сараас эхлэн хэвтэн эмчлүүлэгчдэд зориулсан зориулалтын хөвөн даавуун материалтай хувцсыг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн. Угаалга, ариутгал, халдваргүйтгэл хийгдэн тус тусад нь савлан олгож байна. Энэ үйлчилгээг нэвтрүүлсэнээр эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг бууруулах, шарх эдгэрэлтэнд эерэг нөлөөлөх зэрэг зэрэг давуу талтай.<br>- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд ээлтэй зохион байгуулах хүрээнд хэвтэн эмчлүүлэгчдэд чанарын шаардлага хангасан, халуунаа барьдаг, тагтай хоолны саваар үйлчилж эхэлсэн.<br>- Хавдрын тусламж үйлчилгээний ачааллыг | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өдөр "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал" сэдэвт өдөрлөг, сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 6-р сарын 20-ны өдөр УХТЭийн ҮОЭТ-ийн 1 давхарт амжилттай зохион байгууллаа. | | хуваалцах, үйлчлүүлэгчдийн хүлээгдлийг бууруулах, хавдрын хими эмчилгээний кабинетийг нээн ажиллуулсан. Энэ кабинет нь өдрийн хавдрын эмчилгээг хүргэх 5 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Сард 100 орчим хүн хүлээн авах хүчин чадалтай.<br>- Үйлчлүүлэгчдэдээ зориулан сэтгэл заслын эерэг нөлөө үзүүлэх, эмнэлгийн орчинд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор сонгодог "Хөгжмийн булан"-г нээн ажиллуулж байна. Энэ буланд мэргэжлийн урлагийн байгууллагууд болон сургуулиудын мэргэжлийн хөгжимчид ирж сонгодог хөгжмийг эгшиглүүлдэг.<br>- Эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А/42 дугаар тушаалаар Улсын хоёрдугаар төв эмнэлгээр үйлчлүүлэх журам УХТЭ-БМ-06 ТҮЖ 25:2023-1 журмыг боловсруулан батлан, мөрдөж ажиллаж байна. Энэхүү журамд үйлчлүүлэгчийн үүрэг хариуцлага, эмнэлгийн ажилтны үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан. Үйлчлүүлэгчийн цаг товлох, үйлчилгээ авах үйл явцын зураглал, үйлчлүүлэгч амбулаторийн тусламж, үйлчилгээ авах үйл явцын зураглал, үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх үйл явцын зураглалыг боловсруулан, | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өвчний түүх нээх цэгт болон амбулаторийн давхар бүрт үйлчлүүлэгчийн нүдэнд ил харагдахуйц байрлуулсан.<br>- Өвчний түүх нээх хэсгийг "нэг цэгийн үйлчилгээ" болгон тохижуулж иргэдэд тав тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн. шинээр нээгдэж байгаа хэсэг нь Эмнэлзүйн зохицуулалтын албаны нэг хэсэг бөгөөд "үйлчлүүлэгчдийг дэмжих хэсэг" юм. Энэ цэгт өвчний түүх нээх, үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах бугуйвч зүүлгэх, төлбөр төлөх, Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн асуудалтай холбоотой үйлчилгээ,13 А,Б маягт, эмнэлгийн хуудас авах, хэвтэн эмчлүүлэх үйлчлүүлэгчид эмнэлгийн өвчтөний хувцасаа авах, хувцасаа солих, болон лавлагаа мэдээллийг авах боломжтой.<br>- 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн эмнэлгийн ажилтнуудын автобусыг "Улсын хоёрдугаар төв эмнэлэг-ханын материал чиглэлд явуулж байна. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах | Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчилсан мэдээ, нэвтрүүлэг | Нийгмийн эрүүл мэндийн алба нь цахим сүлжээгээр дамжуулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мөн эмнэлгийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөг хүргэж эхэлсэн. Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэлийн цуврал контентийг 7 төрлийн сэдэвийн хүрээнд явуулсан. 1. Уушги судлалын тасгийн эмч Э.Цээпил 2022 оны 03 сарын 23 нд Корона вируст халдварын дараах уушгины эмгэгийн асуудал сэдвээр иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Лайв контентын хандалт нь 650 хүний үзэлттэй, 29 хүн бусдад цааш түгээсэн /3Иаге/ үзүүлэлттэй байна. | Эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана. | Албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан эрүүл мэндийн ажилтны нэр хүнд, мэргэжлийн онцлог, үйл ажиллагааг сурталчилсан мэдээ, нэвтрүүлэг:<br>2023 онд Улсын хоёрдугаар төв эмнэлэг иргэд олон нийтэд: Албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан эрүүл мэндийн мэдээлэл нэвтрүүлэг- 8<br>Мэдээллийн сайт цахим хуудсанд 30 мэдээллийг иргэд олон нийтэд хүргэсэн байна.<br>Нийгмийн эрүүл мэндийн алба нь цахим сүлжээгээр дамжуулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх мөн эмнэлгийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөг цуврал байдлаар иргэдэд мэдээллийг олгодог.<br>Эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэлийн цуврал контентийг 6 төрлийн сэдэвийн хүрээнд явуулсан.<br>1.Артерийн даралт ихсэх өвчний эрсдэлийг бууруулья, хүндрэлээс сэргийлэх талаар иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Тус контентын хандалт нь 77000 хүний үзэлттэй, 1200 хүн бусдад цааш түгээсэн байна.<br>2. Бөөр хамгаалах дэлхийн өдөр нь 2023.03.09-ний өдөр тохиосон. Энэ жил уг өдрийг “Бөөрөө хайрлацгаая, Гэнэтийн тохиолдолд бэлэн байж | - | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2. Дүрс оношилгооны тасгийн их эмч Ц.Отгонтуяа 2022 оны 03 сарын 30 нд Рентген шинжилгээ ба Ковид гэсэн сэдвээр иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Лайв контентын хандалт нь 1200 хүний үзэлттэй, 87 хүн бусдад цааш түгээсэн/ЗИаге/ төлөвтэй байна.<br>3. Ерөнхий мэс заслын тасгийн их эмч М.Түвшинбаяр 2022 оны 04 сарын 6 нд Хөхний мэс засал эмчилгээ сэдвээр иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Лайв контентын хандалт нь 1786 хүний үзэлттэй, 69 хүн бусдад цааш түгээсэн байна.<br>4. Ерөнхий мэс заслын тасгийн их эмч Б.Ган-Эрдэнэ 2022 | | эрсдэлт бүлгийнхнийг хамгаалъя” уриан дор болсон. Бөөрний архаг өвчнөөс сэргийлэх талаарх зөвлөмж мэдээллийн Лайв контентын хандалт нь 2000 хүний үзэлттэй, 42 хүн бусдад цааш түгээсэн/ЗИаге/ төлөвтэй байна.<br>3. Мэс заслын тасгийн эмч Б.Онон сөөргөө өвчний үеийн оношилгоо болон мэс засал эмчилгээний талаар иргэдэд эрүүл мэндийн зөвлөмж болон мэдээлэл өгсөн. Контентын хандалт нь 13000 хүний үзэлттэй, 177 хүн бусдад цааш түгээсэн байна.<br>4. Хоол боловсруулах тасгийн их эмч Н.Түвшинбаяр Хоол боловсруулах сэдвээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Лайв контентын хандалт нь 20000 хүний үзэлттэй, 21 хүн бусдад цааш түгээсэн байна.<br>5. Ерөнхий мэс заслын тасгийн эмч М.Түвшинбаяр хөхний хортой болон хоргүй хавдрын үеийн оношилгоо, эмчилгээ болон мэс заслын тусламж үйлчилгээ сэдвээр иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөг өгсөн.<br>Энэхүү лайв контентын хандалт нь 489 хүний үзэлттэй, 52 хүн бусдад цааш түгээсэн байна.<br>6. Хүүхдэд чихний үрэвсэл үүсэх шалтгаан илрэх шинж тэмдгийн тухай нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөөг | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | оны 04 сарын 15 нд “Нойр бурчирхайн хавдар” сэдвээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол, зөвлөгө мэдээлэл хүргэсэн. Лайв контентын хандалт нь 3218 хүний үзэлттэй, 200 хүн бусдад цааш түгээсэн байна.<br>5. Ангиографикийн тасгийн их эмч М.Батмөнх 2022 оны 04 сарын 20 нд “Хөлийн судасны эмгэгүүдийн оношилгоо” сэдвээр иргэдэд эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөг өгсөн. Энэхүү лайв контентын хандалт нь 489 хүний үзэлттэй, 52 хүн бусдад цааш түгээсэн байна. | | иргэдэд эрүүл мэндийн боловсрол,олгох зорилгоор хүргэсэн. Лайв контентын хандалт нь 4800 хүний үзэлттэй, 76 хүн бусдад цааш түгээсэн байна.<br>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр эмнэлгийн хамт олон үндэсний цэцэрлэгт хүрээлэнд бүх нийтээр мод тарих өдрийн арга хэмжээнд оролцож, мод тарив. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудсыг эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудастай холбох, үйл ажиллагааг тогтмолжуулах | Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудасны хандалтын тоо | - "Шилэн данс"-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.<br>- Эмнэлгийн ЦАХИМ хуудас "АЖЛЫН БАЙРНЫ ЗАР" буланд 132 удаа нийт 48 ажлын байрны зар, эмнэлгийн FaceЬook хуудас дээр 81 удаа 48 ажлын байрны зарыг байршуулсан<br>- Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд 3 ажлын байрны захиалга өгсөн.<br>- 2022 оны 05 дугаар сарын 09-нд 10-12 цагт Этүгэн их сургуулийн сувилахуйн сургуулийн 67 төгсөгчийг "Сувилагч мэргэжлийн бахархал" сэдэвт эмнэлгийн танилцуулга, тойрон аяллыг зохион байгуулсан.<br>- Энэрэл дээд сургуулийн | Сул ажлын байрны мэдээний нэгдсэн цахим хуудсыг нийт эрүүл мэндийн байгууллагуу; ын цахим хуудастай холбох, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна | - https://info.shilendans.gov.mn/ "Шилэн данс"-д байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг сар бүр тайлагнасан.<br>- "Эрүүл мэндийн ажилтан сонгон шалгаруулж ажилд авах журам"-ыг эмнэлгийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын А/31 дүгээр тушаалаар шинэчлэн батлаж, мөрдөн ажиллаж байна. Журмыг эмнэлгийн албан ёсны цахим хуудсанд нийтэд ил тод байршуулсан.<br>- 2023 оны 06 дугаар сарын байдлаар нийт 27 ажлын байранд 67 удаа сонгон шалгаруулах зарыг эмнэлгийн вэб хуудас, эмнэлгийн фейсбүүк фейж, ЭМХТ-ийн программд ил тод байршуулсан. 2023 оны 06 дугаар сарын байдаар нийт 63 эрүүл мэндийн ажилтан шинээр ажилд орсон. Үүнээс 16 эмч, 22 сувилагч, туслах сувилагч, 12 үйлчлэгч, 13 бусад ажилтнууд байна.<br>- 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Этүгэн их сургууль, 04 дүгээр сарын 21-ний өдөр АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн төгсөх дамжааны оюутнуудтай ажил олгогчдын нэгдсэн уулзалт арга хэмжээнд оролцож шинэ төгсөх сувилагч нарт эмнэлгийн давуу тал, хөгжих боломжоо зэргээр | Сувилагч, үйлчлэгчийн хомсдол байна | - | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | "Ажил олгогчийн нээлттэй хаалганы өдөрлөг"-т байгууллагын танилцуулга, ажлын байрны зарыг видео шторкыг хүргүүлэн оролцсон.<br>- Монгол Улсын хэрэгжүүлэгч агентлаг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын мэргэжилтэн<br>- Н.Дорждэрэмтэй хамтран ажиллаж үйлчлэгч, цахим бүртгэл лавлагааны ажилтны ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах санал, хүсэлтийг хүргүүлсэн. | | танилцуулга хийж, сувилагчаар ажиллах урилга өгсөн.<br>- 2023 оны 04 дүгээр сарын 27-ний өдөр Дархан-уул аймгийн анагаах ухааны сургуулийн ажил олгогч,төгсөгчдийн уулзалтанд байгууллагаа сурталчилах, сувилахуйн хүний нөөцийн бүрдүүлэлт хийх зорилготой оролцож бакалаврын 10, дипломын 4 оюутанд ажлын байрны батламж гардуулсан. | | | |

Тайлан гаргасан: Х.Болор / Захиргаа, хүний нөөцийн албаны менежер/

Тайлан хянасан: Н.Баярмаа /Захиргаа, хүний нөөцийн албаны дарга/